

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗИЙГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХЭРХЭН ХҮЛЭЭН АВАХ ВЭ ?



Өргөн нэвтрүүлгийн телевиз гэж ямар телевиз вэ?

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу олон талт хөтөлбөртэй, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ, олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих телевизийг хэлэх бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч юм.

Өргөн нэвтрүүлгийн телевиз нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Телевизийн хөтөлбөрт тавих шаардлагын дагуу олон талт хөтөлбөр, үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг, орон нутгийн мэдээ, мэдээлэл, хүүхдэд зориулсан болон танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн түгээх нэмэлт үүрэг хүлээж байгаа болно.

Өргөн нэвтрүүлгийн ямар, ямар телевиз байдаг вэ?

Өнөөдөр Улаанбаатар хотод үйлчилгээ эрхэлдэг, Монгол улсын нутаг дэвсгэрт хөтөлбөрөө хүргэх эрхтэй нийт 18 өргөн нэвтрүүлгийн телевиз, аймаг орон нутагт нийт 61 өргөн нэвтрүүлгийн телевиз тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хэрэв та Улаанбаатар хотод амьдардаг бол Монголын үндэсний олон нийтийн телевиз болон өргөн нэвтрүүлгийн 18 телевизийг хүлээн авах боломжтой. *(Одоогоор техникийн боломжоос шалгаалан 16 хүртэлх суваг дамжиж байна).*

Улаанбаатар хотын хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэгч доорх телевизүүд байдаг байна:



Аймаг, орон нутгийн үзэгчдийн хувьд РТС УТҮГ-ын сүлжээгээр орон даяар хөтөлбөрөө дамжуулах эрхтэй өргөн нэвтрүүлгийн телевиз (Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизүүд), Монголын үндэсний олон нийтийн телевизийн 1, 2-р суваг, мөн тухайн аймгийнхаа өргөн нэвтрүүлгийн телевиз нийт 18 хүртэлх телевизийн сувгийг үнэ төлбөргүй хүлээн авах боломжтой байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийг үнэ төлбөргүй хэрхэн хүлээн авах вэ?

Үзэгчид аль нэг олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээг төлбөр төлж авахгүйгээр тухайн хамрах хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийг дараах төхөөрөмж, антенн ашиглан үнэ төлбөргүй хүлээн авах боломжтой.



01
DVB-T2 стандарт
хангасан телевиз эсхүл
энгийн телевиз



02
Антенн болон
антенны
кабель



03

Сет-Топ бокс DVB-T2 стандарт хангасан
телевизтэй бол танд хэрэггүй



Дээрх төхөөрөмж, антенн байхад та агаараар цацагдаж байгаа өргөн нэвтрүүлгийн 18 хүртэлх телевизийг үнэгүй хүлээн авах боломжтой.




Хэрвээ та DVB-T2 стандарт хангасан телевизтэй бол

1. Та өмнө нь хэрэглэж байсан антеннаа хэрэглэж болно.
2. Телевиз болон хүлээн авах антенныг холбосны дараа тоон телевизийн стандартыг дэмждэг телевизээ асаана.
3. Телевиз дээрээ сувгийн хайлт хийж өргөн нэвтрүүлгийн 18 телевизийг шууд хүлээн авч үзэх болно.




Та хуучин телевиз дээр ашиглах бол

1. Та хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмж (Сэт-Топ бокс)-ийг худалдан авах шаардлагатай.
2. Өөрийн ашиглаж байсан антенны кабелийг Сэт-Топ боксд арын үүрэнд холбох хэрэгтэй.
3. Хувиргагч төхөөрөмжийн арын үүрнээс дуу, дүрсний кабелиар телевизын холбогдох үүрүүдтэй холбоно.
4. Телевизийн дэлгэц дээр дүү дүрсний "AV" горимыг сонгоно.
5. Телевиз дээрээ сувгуудыг хайх тохиргоор хийснээр та өргөн нэвтрүүлгийн 18 телевизийг шууд хүлээн авч үзэх боломжтой



ШУУД ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ

Агаараас буюу гэрийн антеннаар телевизийн өргөн нэвтрүүлэг хүлээн авч буй хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл



Та тоон телевизийн нэвтрүүлгийг DVB-T2 Сэт топ бокс ашиглан үзэх бол ...

1-р алхам Та хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмж (Сэт топ бокс)-ийг худалдан авах шаардлагатай.
(Энэ төхөөрөмжийг худалдан авахдаа Монгол Улсын стандартад нийцсэн тохирлын гэрчилгээг шалгахыг зөвлөж байна)

2-р алхам Өөрийн ашиглаж байсан эсхүл шинээр авсан антены кабелийг хэрэглэгчийн хувиргагч төхөөрөмж (Сэт топ бокс)-ийн арын үүрэнд дараах заавраар холбоно.

3-р алхам Хувиргагч төхөөрөмжийн арын үүрнээс дуу, дүрсний кабелиар телевизорын холбогдох үүрүүдтэй холбоно.

Жишээ нь: Дуу дүрсний кабелийг шар өнгөөр тэмдэглэсэн төгсгөлийг телевизорын шар өнгийн оролтод, улан өнгөөр тэмдэглэсэн төгсгөлийг улаан өнгийн оролтод холбоно. Зарим телевизорын оролтуудын өнгө өөр байгаа тохиолдолд шар өнгийн кабелийг шар өнгийн оролтонд, улаан өнгийн кабелийг бусад сул оролтод холбоно.

4-р алхам Телевизорын дэлгэц дээрээ дуу дүрсний "AV" горимыг сонгоно.

5-р алхам Телевизор дээрээ сувгуудыг хайх тохиргоог хийнэ.

Харилцаа холбооны зохицуулах хороо
Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар
Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтэс